

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



**“АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР
НӨЛӨӨ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” ЖИЛИЙН
ХҮРЭЭНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН
ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН”**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439,

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225

Ахлах аудитор Т.Батсайхан
Аудитор Б.Гантуяа

Утас: 7059-2208
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: dundgovi@audit.gov.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	2
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3-4
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. АУДИТААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ, ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГУУД ХАМТАРЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.</u>	5-9
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Аудитаас 7 заалт зөвлөмж өгснөөс 4 нь хэрэгжиж хэрэгжилт 57.1 хувьтай байна.	9-12
Ахлах аудитор Т.Батсайхан	1.2 Аудитаас ҮАГ-аар дамжуулан яамдад хүргүүлэх санал бүрэн дэмжигдэж нэгтгэсэн тайланд орсон байна.	12-13
Аудитор Б.Гантуяа	1.3 Шалгагдагч байгууллагууд аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд хамтарч ажиллаагүй байна.	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт	13
ХАЯГ:		
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот		
2023 оны 11 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНТ	Орон нутгийн төсөв
УТ	Улсын төсөв
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ТХ	Төсөл хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХҮБХЗГ	Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуй
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.3, МУЕА-ын 2022 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”, Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу өөрийн санаачилгаар хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн аудитын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод байдлыг сайжруулах” зорилтын хүрээнд **“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”**-нд хийсэн аудитын үр дүнд өгсөн зөвлөмж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн саналын хэрэгжилтийг ирүүлсэн хариу тайлбар, нотлох баримттай газар дээр нь тулган шалгах, үр дүнг тооцож зорилтын биелэлтийг хангах, аудитын үр дүнг тайлагнахад чиглэнэ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Хяналт шалгалтад илрүүлэлтийн хүснэгтэд тусгасан асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах стандарт, хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ❖ АДБОУС
- ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020
- ❖ МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам
- ❖ МУЕА-ын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан ГА-ын заавар, аргачлал /5.8/

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Дундговь аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, болон бусад холбогдох байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулсан.

Шалгалтыг аудитын матрицад тусгасан асуулт, арга зүй, нотлох баримт цуглуулах аргуудын хүрээнд хийж, нөхцөл байдал, үр дүнг аудитын илрүүлэлтийн хүснэгтээр баримтжуулсан.

Аудитын арга зүй:

Шалгалтыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх,

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын дүн

асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, шалгалтын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа нар 2023 оны 09 дугаар сарын 18-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.



БҮЛЭГ 1. Аудитаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, шалгагдагч байгууллагууд хамтарч ажиллаагүй байна.

1.1 АУДИТААС 7 ЗААЛТ ЗӨВЛӨМЖ ӨГСНӨӨС 4 ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИЖ, ХЭРЭГЖИЛТ 57.1 ХУВЬТАЙ БАЙНА.

1.1.1 Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулж, ажлын хэсэг томилон ажиллуулсан байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд” нэгдсэн удирдамжаар 2021 оны 8 дугаар сараас 11 дүгээр сарын хугацаанд гүйцэтгэлийн аудит хийж аймгийн Засаг даргад 6 заалт, Эрүүл мэндийн газарт 1 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлжээ. “Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичигт хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгагдсан заалт хоорондын уялдаа холбоог хангуулах, тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллах” гэсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24 –ний өдрийн А/411 тоот захирамжаар 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх 5 жилийн төлөвлөгөө боловсруулахыг даалгажээ. Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн тухай хариуг аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 05/1757 тоот албан бичгээр “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт 2022-2026 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийн хамт ирүүлсэн байна. Уг төлөвлөгөөний төсөлд хэрэгжүүлэх арга хэмжээний зорилт, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээ, хамтран хэрэгжүүлэх, байгууллага, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тооцож тусгасан байна. Үүнээс үзвэл эхний зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна гэж дүгнэлээ.

1.1.2 Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад 12,038.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аудитаас “Аймагт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хийгдэх ажлыг тодорхой болгож аймгийн бодлогын баримт бичгүүдэд санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тусгах” зөвлөмж хүргүүлжээ. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт 2022-2026 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 29-н арга хэмжээг 12,034.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

№	Арга хэмжээний тоо	Санхүүжилтийн эх үүсвэр	Нийт санхүүжилтийн дүн	Үүнээс				
				2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он
1	5	ОНТ	356.0	36.0	102.0	58.0	155.0	5.0
2	6	УТ	912.2	419.0	53.7	36.5	346.5	56.5
3	2	ТХ, УТ	9.0		2.0	2.0	2.5	2.5
4	2	Иргэд, ААНБ	8.0		2.0	2.0	2.0	2.0
5	2	ОН, ТХ	60.0		15.0	15.0	15.0	15.0
6	1	ОНТ, ТХ, иргэд	80.0		50.0	20.0	10.0	
7	1	ОНТ, ТХ, малчид	29.0	9.0	5.0	5.0	5.0	5.0
8	1	УТ, ОНТ, ТХ	1,984.0	224.0	480.0	480.0	480.0	320.0
9	2	ОНХС	2,620.0	60.0	100.0	860.0	800.0	800.0
10	4	УТ, ОНТ	5,980.0	80.0	5,900.0			
ДҮН	26		12,038.2	828.0	6,709.7	1,478.5	1,816.0	1,206.0

Нийт арга хэмжээнээс 3-ыг нь төсөв хөрөнгө зарцуулахгүйгээр гүйцэтгэхээр төлөвлөсөн ба



тооцооллын алдаанаас санхүүжилтийн дүнг 4.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөжээ. Энэ нь арга хэмжээг хэрэгжүүлэх явцад санхүүжилт дутагдах, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх сөрөг үр дагавартай тул төсөв төлөвлөгөөний тооцооллыг батлагдахаас өмнө нягтлан шалгаж хэвших нь зүйтэй. Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг харьцуулбал хамгийн олон арга хэмжээ буюу 6 ажлыг

улсын төсвөөр, харин санхүүжилтийн 49.7 хувь буюу 5,980.0 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Үүнээс зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна гэж үзлээ.

1.1.3 Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулах ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

	Хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний тоо
1	30%	1
2	60%	1
3	70%	2
4	80%	2

5	90%	2
6	100%	10
7	Хугацаа болоогүй	9
	дүн	27

Аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах 5 жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулсан боловч тус төлөвлөгөөг 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан

байна. Төлөвлөгөөний төслийг 3 сар гаруй хугацааны дараа хэлэлцэж баталсан нь тодорхой шалтгаангүйгээс гадна зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хугацаа алдсан, ажлын хариуцлагыг сулруулсан үр дагавартай байна. Харин төлөвлөгөөний хэрэгжилтийг давтан аудитын явцад буюу 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр гаргаж ирүүллээ. Ирүүлсэн хэрэгжилтийн дүнгээс үзвэл нийт ажлын 37.0 хувь нь бүрэн, 25.9 хувь нь 50-иас дээш хувийн хэрэгжилттэй гэж дүгнэжээ. Энэ хэрэгжилтэд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийгдээгүй байна.

Аудитын явцад төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж үзвэл дунджаар 57.8 хувьтай байна.

1.1.4 Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих талаар олон нийтэд таниулах ажил хийгдээгүй байна.

Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих талаар аймгийн бодлогын баримт бичигт тусган, үйлдвэрлэл эрхлэгч нарт органик бүтээгдэхүүнд тавигддаг шаардлага, бүртгэлжүүлэлт болон баталгаажуулалтын ажил хэрхэн хийгддэг талаар таниулах, мөн олон нийтэд органик бүтээгдэхүүний ашиг тусын талаар мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

- Хүрэн ус Эс Эф Си Эс ХХК-ний ХХААХҮ-ийн баталгаажуулалтын төвд “органик хүнсний хамтын баталгаажуулалтын байгууллага” болох хүсэлтээ, мөн өөрийн хүлэмжид тариалсан 8 нэр төрлийн хүнсний нарийн ногоог “органик бүтээгдэхүүн болохыг баталгаажуулахаар шаардагдах дээж, материалуудыг өгснөөр тус байгууллагын аудитын хяналт шалгалтаар орж “хамтын баталгаажуулалтын байгууллагын гэрчилгээ авах шаардлагыг хангаж гэрээ байгуулахаар ажиллаж байна.
- Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд 2022 онд ЖДҮХС-аас 3 төсөлд /сүү, сүүн бүтээгдэхүүн, гахай, тахианы аж ахуй/ 220.0 сая, ХХС-аас 3 төсөлд /мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх/ 150.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Үүний хүрээнд 3 шинэ үйлдвэр шинээр бий болж шинэ ажлын байр 18-аар нэмэгдсэн.
- 2023 онд органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаар иргэд олон нийтэд сургалт сурталчилгаа хийгдэхээр төлөвлөгдөж байна гэсэн хариу ирүүлжээ.

Энэ талаар тодруулахад 2023 оны 3 сард зохион байгуулсан мэргэжилтний зөвлөгөөнөөр ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын органик хүнс хариуцсан ахлах мэргэжилтэн “органик түүхий эд бүтээгдэхүүн, хамтын баталгаажуулалтын байгууллагыг хэрхэн байгуулах талаар мэдээллийг ХХАА-н мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчид зэрэг 120 хүнд өгсөн гэх боловч энэ талаар нотлох баримт олдсонгүй.

1.1.5 Хүнсний аюулгүй байдал алдагдах үед ажиллах төлөвлөгөөгүй байна.

Аудитаас хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой аймагт тохиолдож болзошгүй олон нийтийг хамарсан хоол, хүнсний хордлого, халдварт өвчин, хүнсний хомсдол үүсэх болон бусад эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлон, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх,

тодорхой арга хэмжээнүүдийн талаар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлжээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан жил бүр тодотгол хийгдэхээр ажлын хэсгийн 2022-2026 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 01/03 тоот удирдамжийн дагуу баяр наадмын үеэр нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажил үйлчилгээний чанар стандартын шаардлагыг хангуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдэд зөвлөмж зөвлөгөө өгөх зорилгоор хяналт тавьж ажилласан гэсэн хариуг ирүүлжээ. Гэвч хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө байсангүй.

Харин 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 16-ны өдрийг хүртэл хугацаанд хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж гарч баярын үеэр нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажил үйлчилгээний чанар стандартын шаардлагыг хангуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, зөвлөмж зөвлөгөө өгөх зорилгоор хяналт тавьж ажилласан байна.

1.1.6. Орон нутгийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих ажлыг эхлүүлсэн байна.

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутгийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар бодитой ажлуудыг санхүүгийн эх үүсвэрийн хамт төлөвлөн, хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах тухай өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг дараах байдлаар ирүүлсэн байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 2022-2026 оны төлөвлөгөөнд Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох, бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг санхүүгийн эх үүсвэрийн хамт дэмжин оролцуулах, төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. 2022 онд ЖДҮХС—аас 3 төсөлд /сүү сүүн бүтээгдэхүүн, гахай, тахианы аж ахуй/ 220.0 сая, ХХС-аас 3 төсөлд /мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх/ 150.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ. Үүний хүрээнд 3 шинэ үйлдвэр бий болж ажлын байр 18-аар нэмэгдсэн гэсэн хариуг ирүүлжээ. Аудитын явцад хэрэгжилттэй танилцсаныг хүснэгтээр харуулбал:

	Сумын нэр	ААН, иргэний нэр	Зээлийн дүн /сая төгрөг/	Санхүү жүүлэгч	Шинээр нэмэгдсэн ажлын байр
1	Сайнцагаан	Баян зэгстийн говь ХХК	100.0	ХХС	
2	Сайхан-Овоо	Их бадрах хайрхан ХХК	50.0	ХХС	3
3	Өндөршил	Ч.Отгонжаргал	30.0	ХХС	
4	Говь-Угтаал	Үржих эрдэнэ дэвжих ХХК	50.0	ЖДҮХС	4
5	Сайнцагаан	Хишиг өгөөмөр ХХК	70.0	ЖДҮХС	2
6	Сайнцагаан	Жаргалант сор ХХК	100.0	ЖДҮХС	
	дүн		400.0		9

Хүнсний хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжид нийт 400.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын эхлэл тавигдсан байна гэж үзлээ.

1.1.7 Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох ажил хийгдээгүй байна.

Аудитаас “Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн давтагдан гарч буй зөрчил, лабораторийн шинжилгээний дүн, хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалж болох өвчлөлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах” зөвлөмжийг аймгийн ЭМГ-т хүргүүлжээ. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ЭМГ-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 03/572 тоот албан бичгээр хариу ирүүлжээ. Уг албан бичигт Монгол улсын Засгийн газрын 2001 оны “Эрүүл аж төрөх, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх тухай” 224 дүгээр тогтоолын дагуу:

- Давсны хэрэглээг бууруулах
- Дэлхийн усны өдрүүд
- Дэлхийн эрүүл мэндийн өдөр
- Эрүүл гэр бүлийг дэмжих өдрүүд
- Дэлхийн “Зүрхний өдөр”
- Архидан согтуурахаас сэргийлэх өдөр
- Оюутны эрүүл мэндийг дэмжих өдрийн хүрээнд 53 төрлийн постер мэдээллийг түгээж 46,168 хүнд хүргэсэн. Танхимын болон хөдөлгөөнт сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагын 3083, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгч 8548 иргэнд хүргэсэн гэсэн хариуг ирүүлжээ.

Үүнээс үзэхэд аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөлд судалгаа хийсэн, сургалт сурталчилгаа зохион байгуулсан зүйлгүй байна. Иймд ЭМГ-т зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаас өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хэрэгжилт 57.1 хувьтай байгаа нь ажил хариуцсан ажилтнуудын санаачилга, хариуцлагаас шалтгаалсан байна .

1.2 Аудитаас ҮАГ-аар дамжуулан яамдад хүргүүлэх санал бүрэн дэмжигдээж нэгтгэсэн тайланд түсгагдсан байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн”-д нэгдсэн удирдамжаар хийсэн гүйцэтгэлийн аудитаас ҮАГ –аар дамжуулан холбогдох яамдад зөвлөмж хүргүүлэх 6 саналыг уламжилсан байна. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн давтан аудитаар ҮАГ-т уламжилсан санал “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн”-ийн нэгтгэсэн тайлангийн зөвлөмжид тусгагдсан эсэхийг хянаж үзлээ. Үүнийг санал тус бүрээр дүгнэвэл:

1.2.1 Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулах саналыг хүлээн авч Засгийн газарт зөвлөмж хүргүүлсэн байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн аудитаас Монгол Улсын Засгийн газарт “Хүнсний тухай хуулиар үүрэг болгосон” Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах, хянах журам”, “Стратегийн хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшуулал, тэдгээрийг олгох журам”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, хүнсний хангамж, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг сайжруулах” гэсэн зөвлөмжийг ҮАГ-аас хүргүүлжээ. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулах талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх” санал уламжилсныг ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Засгийн газарт хүргүүлсэн зөвлөмжийн 4-д тусгагдсан байна.

1.2.2 Өндөгний үндэсний стандартыг олон улсын стандарт, үндэсний үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулан, баталж, дагаж мөрдүүлэх санал дэмжигдсэн байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн ҮАГ-ын нэгтгэсэн аудитын дүнгээс Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад “Кодексын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Олон улсын хууль, эрх зүйн хорооноос гаргасан стандарт, удирдамж зөвлөмжид нийцүүлэн манай улсад мөрдөж байгаа зарим стандартыг шинэчлэх, хуульд тусгаагүй чухал ач холбогдолтой нэр томъёо, тодорхойлолтыг хуульд нэмж тусгах” гэсэн зөвлөмжийг хүргүүлжээ. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас ҮАГ-аар дамжуулан “Өндөгний үндэсний стандартыг олон улсын стандарт, үндэсний үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулан, баталж, дагаж мөрдүүлэх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх” санал уламжилсныг ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хүргүүлсэн зөвлөмжийн 3-д тусгагдсан байна.

1.2.3 Тогтвортой хөгжлийн зорилго 2-ын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, заавар журмыг олон улсад ашигладаг аргачлалын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг нэгдсэн зохион байгуулалтайгаар хийж байх талаар Засгийн газарт зөвлөмж хүргүүлсэн байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн ҮАГ-ын нэгтгэсэн аудитын тайлангаас Монгол Улсын Засгийн газарт “Улсын их хурал, Засгийн газраас баталсан хүнсний аюулгүй байдлыг хангах богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох” гэсэн зөвлөмжийг хүргүүлжээ. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн аудитаар ҮАГ-аар дамжуулан “Тогтвортой хөгжлийн зорилго 2-ын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, заавар журмыг олон улсад ашигладаг аргачлалын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг нэгдсэн зохион байгуулалтайгаар хийж байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж

хүргүүлэх” санал уламжилсныг УАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Засгийн газрын хүргүүлсэн зөвлөмжийн 1-д тусгагдсан байна.

1.2.4 Хүнсний эрхийн бичиг авах өрхийн амьжиргааны түвшнийг дэмжлэгийн дүнг шатлалтайгаар тогтоох талаар холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлсэн байна.

УАГ-аас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам-д заасны дагуу өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох орлогыг орлуулан тооцох аргачлалыг 3 жил тутамд шинэчлэх, мэдээллийн санг шинэчлэх, хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” гэсэн зөвлөмжийг хүргүүлжээ. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас УАГ-аар дамжуулан “Хүнсний эрхийн бичиг авах өрхийн амьжиргааны түвшнийг тооцохдоо өрхийн орлогын түвшнийг харгалзан үзэх, тухайн хүнс тэжээлийн дэмжлэгээс бусад орлогын хэмжээг тооцож, хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын хэмжээг авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой хэмжээгээр хүнсний дэмжлэгийн дүнг шатлалтайгаар тогтоох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх” санал уламжилсныг УАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хүргүүлсэн зөвлөмжийн 1-д тусгагдсан байна.

1.2.5 Сумдын хүнс, хөдөө аж ахуй хариуцсан албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулахыг Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлжээ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Сумдын хүнс, хөдөө аж ахуй хариуцсан албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хүнсний сүлжээний бүх үе шатад хяналт тавих эрх, үүргийг холбогдох хуулиар олгож, хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх” санал уламжилсныг УАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийн 2¹-д тусгагдсан байна.

1.2.6 Дутагдалтай байгаа лабораторийн тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмжийг ХХАА, ХҮ-ийн сайдад хүргүүлсэн байна.

УАГ-аас Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад “Хүнсний чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораториудын бүртгэлийн системийн уялдааг хангаж, хяналтын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх төрийн холбогдох бусад байгууллагын системтэй уялдуулах” гэсэн зөвлөмжийг хүргүүлжээ. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас

Аудитаас УАГ-аар дамжуулан яамдад хүргүүлэх санал бүрэн дэмжигдэж нэгтгэсэн тайланд тусгагдсан нь аудитын баг үндэслэлтэй, хэрэгжих боломжтой, нотлох баримтад үндэслэсэн дүгнэлт, зөвлөмж, санал дэвшүүлснийг харуулж байна.

¹ Нэгдсэн удирдамжаар “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн УАГ-ын нэгтгэсэн аудитаас Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт “Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, зорилтыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах” гэсэн зөвлөмжийг хүргүүлжээ.

хийсэн тус аудитаас ҮАГ-аар дамжуулан “Дутагдалтай байгаа лабораторийн тоног төхөөрөмжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх тухай зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх” санал уламжилсныг ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгаж Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хүргүүлсэн зөвлөмжийн 6-д тусгагдсан байна.

1.3 Шалгагдагч байгууллагууд аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд хамтарч ажиллаагүй байна.

1.3.1 Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд” хийсэн гүйцэтгэлийн аудитаас аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр тооцохоор тус тус хүргүүлжээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг:

- Аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 05/1757 тоот албан бичгээр хариу ирүүлжээ. Уг албан тоотод ажлын хэсэг байгуулах тухай Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24 –ний өдрийн А/411 тоот, 2022 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/472 тоот захирамжууд, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт 2022-2026 онд хийгдэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, хүнс худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжийг тус тус нотлох баримт болгон хавсарган ирүүлсэн байна.
- ЭМГ-ын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 03/572 тоот албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг хэрэгжүүлсэн тайлангийн хамт ирүүлжээ.

Үүнээс үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлэх холбогдох байгууллага, албан тушаалтнууд зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг ажлын 19-21 хоног хоцроож ирүүлсэн байна.

1.3.2 Өгсөн зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүн багатай байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах талаар ажлын хэсэг байгуулж 5 жилийн төлөвлөгөө боловсруулан тодорхой ажлуудыг хийж эхэлсэн ч мэргэжлийн байгууллагуудын улдаа холбоо хангалтгүй, аюулгүй байдал алдагдах үед ажиллах төлөвлөгөөгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хянах тогтолцоо бүрдээгүй, эрсдэл үүсэх нөхцөл байдал хэвээрээ, хүнсэнд тавьж байгаа хяналт нь цаг үеийн шинжтэй байна. Аудитаас өгсөн зөвлөмжийг тухайн цаг үед улсын болон салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр бусад арга хэмжээнүүдтэй уялдуулан төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж хэрэгжүүлсэн бол илүү үр дүнтэй болохоор байжээ. Зөвлөмжийн хэрэгжилтэд ирүүлсэн албан бичиг бусад баримт материалаас үзэхэд ижил төстэй бусад үйл ажиллагааны тайлан, дүн мэдээгээр аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хаасан гэж дүгнэхээр байна. Ялангуяа ЭМГ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан нь зөвлөмжтэй огт уялдаагүй, өвчлөлийн талаарх статистик мэдээлэл, төлөвлөгөөт үйл ажиллагааны хэрэгжилтийн агуулгатай байна.

1.3.3 Хүнсний аюулгүй байдлын хяналтын чиг үүрэг өөрчлөгдсөн, хяналтын тогтолцоо сайжраагүй байна.

Гүйцэтгэлийн аудитаас хойш Монгол улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр 23-ны өдрийн Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг МХЕГ-ыг татан буулгасантай холбоотой эмчилгээ, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиг үүргийг ЭМГ-т шилжүүлжээ. Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоонд өөрчлөлт орж, шилжсэн чиг үүргийн дагуу аймгийн ЭМГ-т 4 орон тоо нэмэгдсэнээс одоогоор хяналт шалгалтын хэлтсийн дарга, мэргэжилтэн гэсэн 2 орон тоогоор ажиллаж байна. Эдгээр орон тоо нь ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын хэлтэст харьяалагдан, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн ЭМГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Шалгагдагч байгууллагууд аудитаас өгсөн зөвлөмжийн хүрээнд хамтарч ажиллаагүй, хяналтын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон зэргээс шалтгаалан орон нутагт хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо сайжраагүй байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг 1. Аудитаас өгсөн зөвлөмжийг тухайн цаг үед улсын болон салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж шалгагдагч байгууллагууд хамтарч ажилласан бол илүү үр дүнд хүрэх боломжтой байсан байна.

1.1 Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийснээр аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг байгуулагдаж, таван жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.

1.2 Аудитаас ҮАГ-аар дамжуулан холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх саналууд дэмжигдсэнээр улсын хэмжээнд мөрдөгдөх бодлогын баримт бичигт тусгагдсан үр дүнтэй байна.

1.3 Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг шалгагдагч байгууллагууд хамтран төлөвлөж, зохион байгуулж ажиллаагүй байна.

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 